



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 16 одор

Дугаар A/160

Улаанбаатар хот

Шинээр байгуулагдсан тэнхимүүдийн
эрхлэгчийн сонгон шалгаруулалт явуулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.16, 4.9.18, 4.9.21 дэх заалт, сургуулийн Хөдөлмөрийн дотоод журам, ШУТИС-ийн Мэргэжлийн тэнхимиийн үйл ажиллагааг зохицуулах журам, Хүний нээцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журмын холбогдох заалтууд, ШУТИС-ийн Ректорын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн “Салбар, тэнхимүүдийг татан буулгах, тэнхимүүдийг шинээр байгуулах тухай” А/152 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Тус их сургуулийн бүрэлдэхүүн, салбар сургуулиудын шинээр байгуулагдсан тэнхимүүдийн эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах нийтлэг удирдамжийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Барилга, архитектурын сургууль, Гадаад хэлний сургууль, Геологи, уул уурхайн сургууль, Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль, Менежментийн сургууль, Механик инженер, тээврийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Нийгэм, хүмүүнлэгийн сургууль, Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Эрчим хүчний инженерчлэлийн сургууль, Ахисан түвшний сургуулиудад шинээр байгуулагдсан тэнхимиийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалтыг 1 дүгээр хавсралтаар баталсан нийтлэг удирдамжийг баримтлан, тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын тушаалаар баталсан удирдамжийн дагуу сургууль тус бүр дээрээ зохион байгуулахыг бүрэлдэхүүн, салбар сургуулиудын захирлуудад зөвшөөрсүгэй.

3. Бүрэлдэхүүн, салбар сургуулиудын шинээр байгуулагдсан тэнхимиийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Тэнхимиийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалтыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны дотор багтаан зохион байгуулж, үр дүнг нэгтгэн Захиргааны удирдлагын газар (Б.Түмэндэлгэр)-т хүргүүлэхийг сонгон шалгаруулалтын комиссын ахлагч нарт үүрэг болгосугай.



367040852



БҮРЭЛДЭХҮҮН, САЛБАР СУРГУУЛИЙН ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ НИЙТЛЭГ УДИРДАМЖ

Бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал нь тухайн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах Удирдамжийг энэхүү нийтлэг удирдамжид нийцүүлэн боловсруулж батална.

Ректорын тушаалаар батлагдсан тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах комисс нь удирдамжийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулж, үр дүнгийн тайлан, холбогдох материалыг Захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.

Тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулиудын тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулах комисс бүр тэнхимийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалтын зарыг өөрсдөө боловсруулж, нийтэд хүргэх ба ШУТИС-ийн албан ёсны вэб хуудаст заавал байршуулна. Бусад вэб хуудас, сошиал сувгууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан зар түгээх нь нээлттэй. Зар байршуулах хугацаа ажлын 5 өдрөөс багагүй байна.

Сонгон шалгаруулалтын комисс тус бүр дотроо хэлэлцэж, нарийн бичгийн даргаар их сургуулийн захиргаанаас томилогдсон төлөөллөөс бусад аль нэг гишүүнийг сонгоно.

Сонгон шалгаруулалт зохион байгуулах хугацаа: 2025.05.19 – 2025.05.30

Сонгон шалгаруулалтад баримтлах нийтлэг зарчим:

Тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа хүний эрх, нэр төр, мэргэжлийн нэр хүндийг хүндэтгэх, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүслээр нь ялгavarлан гадуурхахгүй байх, тэгш хандах, хууль тогтоомж, шударга ёсыг дээдлэх, нууцыг хадгалах, нээлттэй ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.

Нэр дэвшигчид тавих шаардлага:

А. Бүрэлдэхүүн, салбар сургуулийн тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшигч нь дараах шалгуур, шаардлагыг хангасан байна.

1. Доктор (Ph.D)-с доошгүй эрдмийн зэрэгтэй;
2. Тухайн тэнхимийн сургалт, судалгааны аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн;
3. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан;
4. Багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дадлага, туршлагатай;
5. Мэргэжлийн чиглэлээр салбartaа нэр хүндтэй, хариуцсан нэгжийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн холбоог хөгжүүлэх чадвартай;

Б. Нэр дэвшигчийг тухайн их сургуулийн профессор, багшаар хязгаарлахгүй бөгөөд дээрх шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн сонгон шалгаруулалтад оролцох боломжтой.

В. Сонгон шалгаруулалтад оролцогч зөвхөн нэг тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвших эрхтэй.

Нэр дэвшигчийн бүрдүүлэх баримт бичиг:

А. Нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Сонгон шалгаруулалтад оролцогчийн гараар бичсэн хүсэлт;
2. Төрийн албан хаагчийн анкет, зурагтай (Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор баталсан анкет);
3. Иргэний үнэмлэхийн хуулбар (E-mongolia системээс авсан лавлагаа);



ШУТИС-ийн Ректорын 2025 оны 05 дугаар сарын
16-ний өдрийн 5 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

4. Боловсролын түвшин, эрдмийн зэрэг цолыг тодорхойлсон баримт бичиг (хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах)-ийн хуулбар;
5. Ажлын туршлагын шаардлагыг хангасан тухай нотлох баримт (нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр, албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал шийдвэр г.м.)-ийн хуулбар, лавлагаа;
6. Бүтээлийн жагсаалт;
7. Тэнхимийг хөгжүүлэх морийн хотолбор. Морийн хотолбор нь дараах агуулгатай байна. Үүнд:
 - 7.1. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-ний стратегийн үндсэн зорилт, чиглэлийн хүрээнд тухайн Тэнхимд хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
 - 7.2. Тэнхимиийн хэрэгжүүлдэг сургалтын хөтөлбөрүүдээр суралцагчийн тоог нэмэгдүүлэх, сургалтын чанар, материаллаг баазыг дээшлүүлэх, хөтөлбөр хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн;
 - 7.3. Тэнхимиийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, мэргэжлийн үйлчилгээ болон оюутны үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн;
 - 7.4. Тухайн тэнхимиийн хөгжлийг хангахад чиглэсэн өөрийн санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажил, төсөл, хөтөлбөр;
 - 7.5. Хөтөлбөрийг 3 жилээр боловсруулсан байна.

Тайлбар: Бүрдүүлсэн баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргасан иргэн өөрөө бүрэн хариуцна.


Б. Сонгон шалгаруулалтын комисс нэр дэвшигчдийн ирүүлсэн материалтай танилцаж, нэр дэвшигч тус бүрээр материалын бүрдэл хангасан эсэх, нэр дэвшигч нь тавигдсан шалгуур шаардлагыг хангаж байгаа эсэх, боловсруулсан мөрийн хөтөлбөр нь дээр дурдсан агуулгатай нийцэж байгаа эсэхийг нягтална.

В. Нэр дэвшигч нь дээр заасан шалгуур шаардлагыг хангагүй, бичиг баримтын бүрдэл дутуу бол тухайн нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтаас хасах үндэслэл болно.

Сонгон шалгаруулалтын үр дүн, шийдвэр гаргалт:

1. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа дуусахад Сонгон шалгаруулалтын комисс нь сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны тайлан, хурлын тэмдэглэл, шалгарсан нэр дэвшигчийн холбогдох материалын төслийн хуудсууд болон бусад баримт бичгийг нэгтгэн 2025.06.02-ны дотор Захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.
2. Захиргааны удирдлагын газар бүрэлдэхүүн, салбар сургуулиудын ирүүлсэн материалыг нэгтгэн, үр дүнг Ректорт танилцуулсандаа Ректор тэнхимиийн эрхлэгчдийг томилно. Шаардлагатай тохиолдолд тухайн комисс, нэр дэвшигчээс нэмэлт мэдээлэл, тодруулга авч болно.
3. Хэрэв сонгон шалгаруулалтад оролцохор нэг ч иргэн материал ирүүлээгүй бол тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал тэнхимиийн эрхлэгчийн албан тушаалын шаардлага хангасан нэр дэвшигчдийг Ректорт санал болгоно. Ректор санал болгосон нэр дэвшигчдийн холбогдох материалын танилцаж, ярилцлага хийсний үндсэн дээр сонгож, сонгогдсон нэр дэвшигчийг тэнхимиийн эрхлэгчээр томилно.

Маргаан, гомдол шийдвэрлэх: Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан маргаан, гомдлыг бүрэлдэхүүн, салбар сургуулийн сонгон шалгаруулалтын комисс зохих журмын хүрээнд шийдвэрлэнэ.



ШУТЫС-ийн Ректорын 2025 оны 05 дугаар сарын
16.-ний өдрийн 16 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**Барилга, архитектурын сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**


Дарга:	Б.Нарантуяа	БАС-ийн захирал, доктор (Ph.D)
Гишүүд:	Э.Ганзориг	БАС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D), профессор
	И.Гончигбат	БАС-ийн Ахмадын салбар зөвлөлийн дарга, доктор (Ph.D), профессор
	Б.Аюурзана	БАС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, ахлах багш, доктор (Ph.D), дэд профессор
	Б.Өлзий	Захиргааны удирдлагын газрын чанарын ахлах менежер, доктор (Ph.D)

**Гадаад хэлний сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**

Дарга:	Ц.Энхбаатар	ГХС-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор
Гишүүд:	Э.Чимэдлхам	ГХС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, ЭНБД, доктор (Ph.D)
	Т.Батбаяр	ГХС-ийн Ахмадын салбар зөвлөлийн дарга, доктор (Ph.D), профессор
	С.Бархас	ГХС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, профессор, доктор (Ph.D), дэд профессор
	М.Зулбаяр	ИБТА-ны дарга

**Геологи, уул уурхайн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**

Дарга:	К.Хавалболот	ГУУС-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор
Гишүүд:	Б.Мөнхцэнгэл	ГУУС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, профессор, доктор (Ph.D), профессор
	Ц.Нанзад	ГУУС-ийн Ахмадын салбар зөвлөлийн гишүүн, академич, доктор (Sc.D), профессор



Ц.Цэнд-Аюуш ГУУС-ийн Эрдмийн зөвлөлийн
АГДОЛОНН гишүүн, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-
ын хэлтсийн дарга, доктор (Ph.D)
М.Эрдэнэтуяа СБЗА-ны дарга, доктор (Ph.D)

**Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**

Дарга:	Ц.Батбаатар	ДАТС-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор
Гишүүд:	Д.Баясгалан	ДАТС-ийн Эрдмийн зөвлөлийн гышүүн, ЭНБД, доктор (Ph.D), дэд профессор
	Ж.Амгалан	ДАТС-ийн Ахмадын салбар зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D), профессор
	Н.Одонтuyaа	ДАТС-ийн Эрдмийн зөвлөлийн гышүүн, СЧА-ны дарга, доктор (Ph.D)
	Д.Батдорж	Ахисан түвшний сургуулийн ахлах мэргэжилтэн

**Менежментийн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**

Дарга:	Г.Баттүвшин	МС-ийн захирал, доктор (Ph.D), профессор
Гишүүд:	Т.Сүмжидмаа	МС-ийн Эрдмийн зөвлөлийн гышүүн, ахлах багш, доктор (Ph.D), дэд профессор
	Г.Батхүрэл	МС-ийн Ахмадын салбар зөвлөлийн дарга, доктор (Sc.D), профессор
	Б.Цэрэгмаа	МС-ийн Эрдмийн зөвлөлийн гышүүн, ахлах багш, доктор (Ph.D)
	Б.Одгэрэл	ХШДАА-ны дотоод аудитор, доктор (Ph.D)

**Механик инженер, тээврийн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**

Дарга:	Н.Пүрэвдорж	МИТС-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор
Гишүүд:	М.Дэлгэрнасан	МИТС-ийн Эрдмийн зөвлөлийн гышүүн, СЧА-ны дарга, доктор (Ph.D), дэд профессор



Б.Баярсүрэн МИТС-ийн Ахмадын салбар
зөвлөлийн дарга, доктор (Ph.D),
профессор

П.Өлзийсайхан МИТС-ийн Эрдмийн зөвлөлийн
гишүүн, салбарын эрхлэгч, доктор
(Ph.D), дэд профессор
Ц.Цоггэрэл ЭШТХА-ны дарга, доктор (Ph.D)

**Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**

Дарга:	Л.Баяр-Эрдэнэ	МХТС-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор
Гишүүд:	Х.Загарзүсэм	МХТС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, ЭНБД, доктор (Ph.D), дэд профессор
	Б.Отгонбаяр	МХТС-ийн Ахмадын салбар зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D), профессор
	П.Ууганбаяр	МХТС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, СЧА-ны дарга, доктор (Ph.D)
	Ө.Батбаатар	ГХА-ны ахлах мэргэжилтэн

**Нийгэм хүмүүнлэгийн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**

Дарга:	Я.Төгөлдөр	НХС-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор
Гишүүд:	Л.Амартувшин	НХС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, ЭНБД, доктор (Ph.D), дэд профессор
	Б.Долгор	НХС-ийн Ахмадын салбар зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D), профессор
	С.Туяа	НХС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, ахлах багш, доктор (Ph.D), дэд профессор
	Д.Цогзолмаа	ОҮА-ны даргын үүрэг гүйцэтгэгч, доктор (Ph.D), дэд профессор

**Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**

Дарга:	Б.Тунгалагтамир	ХШУС-ийн захирал, доктор (Ph.D), дэд профессор
Гишүүд:	Б.Авид	ХШУС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, академич, доктор (Sc.D), профессор



ШУТЫС-ийн Ректорын 2025 оны 05 дугаар сарын
16-ний өдрийн 16 дугаар тушаалын 2 дугаар хавсралт
Г.Мөнхсайхан A1161 908708
ХШУС-ийн Эрдмийн зөвлөлийн
гишүүн, ЭНБД-ын үүрэг гүйцэтгэгч,
доктор (Ph.D), профессор

Д.Буяントгох

ХШУС-ийн Ахмадын салбар
зөвлөлийн дарга, доктор (Ph.D),
профессор

Ц.Сэрчмаа

ТДША-ны мэргэжилтэн

**Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**

Дарга:

Н.Ганзориг

ХХҮДС-ийн захирал, доктор (Ph.D),
дэд профессор

Гишүүд:

Д.Энхтуяа

ХХҮДС-ийн Эрдмийн зөвлөлийн
гишүүн, академич, доктор (Sc.D),
профессор

Ц.Энхтуул

ХХҮДС-ийн Ахмадын салбар
зөвлөлийн дарга, доктор (Ph.D),
дэд профессор

Т.Баясаа

ХХҮДС-ийн Эрдмийн зөвлөлийн
гишүүн, ЭНБД, доктор (Ph.D)

Г.Ариунтөгс

СБЗА-ны ахлах мэргэжилтэн

**Эрчим хүчний инженерчлэлийн сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг
сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүн**

Дарга:

Бя.Бат-Эрдэнэ

ЭХИС-ийн захирал, доктор (Ph.D),
дэд профессор

Гишүүд:

Б.Пүрэвсүрэн

ЭХИС-ийн Эрдмийн зөвлөлийн
гишүүн, профессор, доктор
(Ph.D), дэд профессор

А.Түмэнбаяр

ЭХИС-ийн Эрдмийн зөвлөлийн
гишүүн, ахлах багш, доктор (Ph.D)

Ч.Нацагдорж

ЭХИС-ийн Ахмадын салбар
зөвлөлийн дарга, доктор (Ph.D),
профессор

Н.Мөнхөө

ТДША-ны дарга, доктор (Ph.D),
дэд профессор